



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 830

Арвайхээр

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29.1.5-ийн “в”, 29.1.6-ийн “л”, “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 10.2, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хуулийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 3 дугаар багийн Түгий овооны 3-25-12 тоотын иргэн Д. Дүгэр, 3-25-10 тоотын М.Батсүрэн, 3-32-10 тоотын Д.Ганзориг нарын үхэрт малын гоц халдварт шүлхий өвчин гарсан нь Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 18-542 бүртгэлийн дугаар бүхий шинжилгээгээр баталгаажсан тул Түгий овооны орчимд 2018 оны 3 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм тогтоосугай

2. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа (Д. Бэхбаяр)-д даалгасугай.

3. Сумын нутаг дэвсгэрт хэв журмыг хангаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, явган хүний болон авто замын хөдөлгөөний хязгаарлалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Нямдаваа)-д даалгасугай.

4. Малын гоц халдварт шүлхий өвчин гадагш тархахаас хамгаалж хорио цээрийн дэглэм сахиулах, голомтын бүсэд ажиллах хяналтын постод техник хэрэгсэл, хүн хүч дайчлан гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Хоролсүрэн), шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах сан, Мал хамгаалах сангаас гаргахыг Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч (Ц.Пүрэвсүрэн) нарт даалгасугай.

5. Шүлхий өвчин халдварласан байж болзошгүй малд үзлэг, тандалт судалгаа хийж, ариутгал халдваргүйжүүлэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга, Мал эмнэлэг, хүнс худалдааны Улсын байцаагч (Б.Ариунцэцэг), “Баян сүргийн буян”, “ДС-Дөхөм”, “Үржин дэвших” хувийн хэвшлийн мал эмнэлгүүдэд тус тус үүрэг болгосугай.

6. Голомтын бүсэд байгаа айл өрхийг цэвэр усаар хангах ажлыг зохион байгуулахыг аймгийн “Онги ус суваг”-ийн Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (О.Лхагвасүрэн)-д даалгасугай.

371100059



7. Голомтын бүсэд томилогдон ажиллаж байгаа гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн албан хаагчид, голомтын бүсэд байгаа иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг хяналтанд авах, шаардлагатай эм тарианы нөөцийг бүрдүүлэх, эрсдэлтэй бүлгийн судалгааг гаргаж ажиллахыг Эрүүл Мэндийн газар (Шиваанүрдэв)-д даалгасугай.

8. Сумын хэмжээнд амьд мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөн, нийтийг хамарсан уралдаан тэмцээн арга хэмжээг зохион байгуулахыг тодорхойгүй хугацаагаар хориглосугай.

9. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үүрэг болгох нь:

а) мал, амьтан гэнэт олноор хорогдсон, халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд 12 цагийн дотор дуудлага өгч мэдэгдэх

б) эрүүл өвчтэй малыг тусгаарлах, малын эмчийн зөвшөөрөлгүйгээр шилжилт хөдөлгөөн хийхгүй байх

в) хорио цээрийн дэглэмийг чанд сахих, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг дагаж мөрдөх

г) Төв захын орчимд малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн болон өвс, тэжээл худалдаалахыг хориглосугай.

10. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын штабын дарга (Т.Чинзориг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. ПҮРЭВДОРЖ